

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/4/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2019 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
	Утас: 70522734 Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.GOV.MN
	Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
	Утас: 70523020 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
	Аудитор: У.Оюунтүлхүүр, О.Нарангарав
	Утас: Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Narangarav.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	10
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	11
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	14
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан	16
3.1	Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	16
3.2	Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	18
3.3	Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	21
3.4	Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	24
3.5	Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	25

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.04.01 № 1-6/386

танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ОДБАЯР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сайншанд сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сайншанд сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сайншанд сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Сайншанд сумын Төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Одбаяр -д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Сайншанд сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.25-наас 2019.03.30-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.04.01-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Нарангарав, У.Оюунтүлхүүр хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.23-ны өдрийн 5/86 дугаар бүхий албан бичгээр 2019.03.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Сайншанд сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын Засаг дарга нь “Иргэдийнхээ эрх ашгийг дээдэлж, төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шударга, шуурхай хүргэж, иргэн төрийн итгэлцлийг дээшлүүлэн, хамтын ардчилсан зарчмаар хотоо хурдан хөгжүүлэхийг эрхэмлэнэ” гэж үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Сайншанд сумын Засаг дарга үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын үйл ажиллагааг төвлөрүүлэн захирах

Сайншанд сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 32 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 32 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Сайншанд сумын Засаг даргын эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	14	14		28	
2	ТТЗ	1	3			
Дүн		15	17		28	

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сайншанд сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сайншанд сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын Засаг даргын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “” програм хангамж ашигладаг байна.

Сайншанд сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сайншанд сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр цэвэр хөрөнгийн 1 хувиар сонгов.

Цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатны суурийг хэвээр авсантай холбоотой юм.

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны цэвэр хөрөнгө 39,911,583.8 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 399,115.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дундаж хувиар сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Сайншанд сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 350,117.3 мянга, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 1,617,691.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 1,646,919.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв. Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Зардал

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 59,581.7 мянган төгрөгийг зарцуулахдаа засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүй захирамж гарган зарцуулсан. 27,543.9 мянган төгрөгийн хөрөнгийн шинжтэй худалдан авалт хийсэн, 31,109.0 мянган төгрөгийн нөөц бүрдүүлээгүй журам зөрчсөн.

Шийдэл:

Уг зөрчлийг дахин давтаж гаргахгүй байх, хууль дүрэм журмыг зөрчихгүй байх тухай зөвлөмж өгсөн

Асуудал 2: Зардал

СЗДТГазар нь Батлагдсан төсвийн санхүүжилтээр худалдан авалт хийхдээ харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоогүй шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн байна. Нийт 51035.4 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн байна.

Шийдэл:

ТБОНӨБАҮХАТухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн

Уг зөрчлийг дахин давтаж гаргахгүй байх, ТБОНӨБАҮХАТухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн

Асуудал 3: Зардал

Сайншанд сумын захирагчийн ажлын алба нь нэмэлт санхүүжилтийн дансаар бараа үйлчилгээний ангилалд 23,575.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Уг санхүүжилтийг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллага иргэнд түлш шатахууны хөнгөлөлт болгон өгсөн байна. Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгүүлэх гэрээг байгуулахдаа сонгон шалгаруулсан тендерийн баримт бичиг байхгүй, худалдан авсан бараа бүтээгдэхүүнд хүчин төгөлдөр баримт хавсаргаагүй байна.

Шийдэл:

Худалдан авалт бүрд Е баримт хавсаргах, худалдан авах үйл ажиллагааны анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, ТБОНӨБАҮХАТухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн

Асуудал 4: Зардал

Сайншанд ИТХурал нь бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын 21,700.0 мянган төгрөгийг зарцуулахдаа шууд худалдан авалт хийсэн байна.

Шийдэл:

ТБОНӨБАҮХАТухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Үүнээс: Залруулгын ангилал			
			Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1	Нэгтгэл тайланд үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлан дахь орлого зардлыг бүртгэлийг буруу ангилан бүртгэсэн	482,474.9		482,474.9		
2	Нөхөн сэргээх сангийн барьцаа хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1,000.0		1,000.0		
	Дүн	483,474.9		483,474.9		

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Илрүүлэлт 1: Нэгтгэл тайланд үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлан дахь орлого зардлыг бүртгэлийг буруу ангилан бүртгэсэн

Шийдвэрлэсэн: Нэгтгэл тайлангийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайлан дахь орлого зардлыг зөв ангилан залруулан бүртгэв

Илрүүлэлт 2: Нөхөн сэргээх сангийн барьцаа хөрөнгийн дансанд 4 газрын 1000.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байхад бүртгэл тайланд тусгаагүй

Шийдвэрлэсэн: Нөхөн сэргээх сангийн дансанд төвлөрүүлсэн 1000.0 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд залруулан бүртгэв

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сайншанд сумын Засаг даргын тайланд нийт 32 байгууллага, сан нэгтгэгддэг бөгөөд ТШЗ-8, ТТЗ-4 газар нийт 12 газар санхүүгийн тайлан хугацаанд нь ирүүлээгүй байна

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сайншанд сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 245 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 13,218,298.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны төсвийг 2017 оны 12 сарын 10-ны өдрийн Сумын ИТХ-ын 06/03 тогтоолоор баталсан бөгөөд 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 14 тогтоолоор тодотгол хийсэн байна.

Сумын татварын болон татварын орлогыг 1,402,900.0 мянган төгрөгөөр татварын бус орлогыг 204,591.0 мянган төгрөгөөр нийт орлогыг 1,607,491.0 мянган төгрөгөөр баталсан байна. Тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 10,414,359.6 мянган төгрөг, СХСангийн орлого- 313,000.0 мянган төгрөг, ОНХСангийн санхүүжилт 377,221.5 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс санхүүжих 487,187.7 мянган төгрөгөөр нийт төсвийн орлогыг 13,199,259.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын орон нутгийн байгууллагын санхүүжилт 2094,678.0 ОНХСан 377,221.5 мянган төгрөгөөр, СХСан 313,000.0 мянган төгрөг, тусгай шилжүүлгийн байгууллагын шилжүүлэг 10,414,359.6 мянган төгрөгөөр нийт төсвийн зарлагыг 13,199,259.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 1,588,953.0 мянган төгрөг буюу 98.8 хувь байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

Орлогын нэр төрөл	Жилийн Төлөвлөгөө	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I.НИЙТ ОРЛОГЫН ДҮН	1,607,491,000.00	1,607,491,000.00	1,588,953,017.53	(18,537,982.47)	98.8
II.УРСГАЛ ОРЛОГО	1,607,491,000.00	1,607,491,000.00	1,588,953,017.53	(18,537,982.47)	98.8
III.ТАТВАРЫН ОРЛОГО	1,402,900,000.00	1,402,900,000.00	1,383,776,317.53	(19,123,682.47)	98.6
1.Орлогын албан татвар	829,400,000.00	829,400,000.00	884,958,977.07	55,558,977.07	106.7
1.1. Хүн амын орлогын татвар	829,400,000.00	829,400,000.00	884,958,977.07	55,558,977.07	106.7
1.1.2. Үйл ажиллагааны орлогын татвар	130,900,000.00	130,900,000.00	131,879,820.30	979,820.30	100.7
1.1.6. Бусад орлогын татвар	698,500,000.00	698,500,000.00	753,079,156.77	54,579,156.77	107.8
2.ӨМЧИЙН АЛБАН ТАТВАР	5,500,000.00	5,500,000.00	5,549,000.00	49,000.00	100.9
2.2. Бууны албан татвар	5,500,000.00	5,500,000.00	5,549,000.00	49,000.00	100.9
4. БУСАД ТАТВАР	568,000,000.00	568,000,000.00	493,268,340.46	(74,731,659.54)	86.8
4.1. Улсын гэмдэгтийн хураамж	160,000,000.00	160,000,000.00	166,786,354.38	6,786,354.38	104.2
4.6. Хог хаягдлын хураамж	108,000,000.00	108,000,000.00	120,949,147.00	12,949,147.00	112.0
4.8.Түгээмэл тархацтай ашигт малтмал	300,000,000.00	300,000,000.00	205,532,839.08	(94,467,160.92)	68.5

IV. ТАТВАРЫН БУС ОРЛОГО	204,591,000.00	204,591,000.00	205,176,700.00	585,700.00	100.3
2. Хүү торгуулийн орлого	4,000,000.00	4,000,000.00	4,362,200.00	362,200.00	109.1
3. Татварын бус бусад орлого	200,591,000.00	200,591,000.00	200,814,500.00	223,500.00	100.1
3.1. Нэр зааж ангилагдаагүй орлого	200,000,000.00	200,000,000.00	200,110,500.00	110,500.00	100.1
3.2. Төсөвт байгууллагын өөрийн орлого	591,000.00	591,000.00	704,000.00	113,000.00	119.1

Татварын орлого тасарсан шалтгаан нь Түгээмэл тархацтай ашигт матмал ашигласны төлбөр 94,467.2 мянган төгрөгөөр тасарснаас шалтгаалсан байна. Уг төлбөрийн төлөвлөгөөг Сумын засаг даргын баталснаар Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч талуудтай зөвшөөрөл олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ хийсэн дүнгээр тусгасан байна. Гэтэл 2018 онд уг гэрээ хийсэн ашиглагч талууд нөөцийг бүрэн ашиглаагүй тул төлбөрийг ашигласан хэмжээгээр төлсөн байна.

Сумын орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 2,022,353.3 мянган төгрөг 98.6 хувьтай, тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 10,397,609.1 мянган төгрөг буюу 99.7 хувь, ОНХСангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 220,022.2 мянган төгрөг, урсгал зардлын гүйцэтгэл 155,175.6 мянган төгрөг нийт 375197.8 мянган төгрөг буюу 99.1 хувь, СХСангийн гүйцэтгэл 237,999.2 мянган төгрөг буюу 76 хувь, нийт төсвийн гүйцэтгэл нь 13,077,983.8 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Аймгаас 511,134.9 мянган төгрөгийн татаас санхүүжилт авч, сумын орон нутгийн төсөвт байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдэл 32,963.1 мянган төгрөгийг аймгийн төсөвт, нэмэлт дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 12,140.6 мянган төгрөгийг авлагаар бүртгэж сумын орлогод төвлөрүүлсэн байна.

Тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн хэмнэлт 45,815.4 мянган төгрөг, нэмэлт дансны үлдэгдэл 130,342.0 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус татан төвлөрүүлж, буцааж авахаар 122,421.7 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн байна.

Төсөв батлахдаа Зүүнбаян багийн Соёлын төвийн өөрийн орлого 1,860.2 мянган төгрөгийг тусгаагүй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Сайншанд сумын Засаг даргын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

СХСангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй иргэдийг шүүхэд шилжүүлэн эвлэрүүлэн зуучлахаар шийдвэрлүүлж 17 иргэний 76,169.5 төгрөгийн зээл, зээлийн хүү, алдангийг барагдуулсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 83.7 хувь буюу 1,646,919.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1.7 хувь буюу 34,725.0 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 1.1 хувь буюу 21,376.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 13.5 хувь буюу 264,787.5 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ			7	1,617,691.2	7	1,617,691.2	7	1,617,691.2
2	ТШЗ	64	320,889.1	7	29,228.2	70	350,117.3	7	29,228.2
	Дүн	63	320,889.1	14	1,646,919.4	77	1,967,808.5	14	1,646,919.4

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ												
2	ТШЗ	63	320,889.1	12	34,725.0	2	21,376.6	49	264,787.5				
	Дүн	63	320,889.1	12	34,725.0	2	21,376.6	49	264,787.5				

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сайншанд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр			Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	
1	ТШЗ	11	3		14
2	ТТЗ	1			1
	Дүн	12	3		15

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,645,382,423.39	2,932,166,471.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,734,072.62	142,432,487.46
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	43,734,072.62	142,432,487.46
31210	Төгрөг	43,734,072.62	142,432,487.46
31211	Төрийн сангийн харилцах	41,257,521.91	140,495,293.23
31213	Арилжааны банк дахь харилцах	123,283.12	1,930,703.27
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	2,353,267.59	6,490.96
33	АВЛАГА	1,180,286,053.78	1,249,221,871.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	14,345,723.45	6,486,014.64
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,000,000.00
33400	Зээлийн хүүгийн авлага	-	24,758,336.00
33500	Бусад авлага	145,513,221.25	252,013,171.10
33510	Байгууллагаас авах авлага	144,281,623.86	247,579,255.10
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,231,597.39	4,433,916.00
33600	Зээлийн авлага	1,020,427,109.08	964,964,350.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	1,020,427,109.08	964,964,350.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	1,020,427,109.08	964,964,350.00
34	УРЬДЧИЛГАА	94,360,300.00	51,470,547.00
34600	Урьдчилж гарсан зардал	87,440,300.00	44,550,547.00
34710	Урьдчилгаа тооцоо	6,920,000.00	6,920,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,920,000.00	6,920,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,327,001,996.99	1,489,041,564.95
35100	Түүхий эд материал	195,094,900.68	307,086,699.12
35110	Тусгай зориулалттай материал	181,357,639.80	296,218,592.59
35130	Эм боох материал	13,737,260.88	10,868,106.53
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2,047,900.00	1,000,000.00
35400	Хангамжийн материал	1,126,129,196.31	1,175,983,865.83
35410	Бичиг хэргийн материал	39,089,188.00	42,648,188.00
35420	Аж ахуйн материал	702,256,604.24	744,501,625.47
35430	Сэлбэг хэрэгсэл	19,285,787.42	28,761,621.65
35440	Түлш, шатах тослох материал	18,958,407.62	16,672,896.54
35450	Барилгын засварын материал	9,620,668.40	2,501,810.00
35460	Хүнсний материал	42,989,882.94	42,839,478.44
35470	Бусад хангамжийн материал	293,928,657.69	298,058,245.73
35500	Биологийн хөрөнгө	-	6,000.00
35600	Мал амьтад	3,730,000.00	4,965,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,741,601,026.85	37,048,010,279.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,741,601,026.85	37,048,010,279.46
39200	Биет хөрөнгө	30,730,809,239.57	34,015,436,796.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	28,920,655,414.59	24,219,286,914.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(9,493,864,528.35)	(131,286,706.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,112,326,013.95	1,363,778,047.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	(742,509,734.02)	(982,664,949.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,313,702,910.73	2,554,865,172.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,516,773,781.51)	(1,803,044,424.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,215,476,315.58	1,446,961,762.68
39208	Хуримтлагдсан элэгдэл	(641,137,749.95)	(765,654,881.82)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,994,154,973.88	2,572,841,437.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(558,126,108.16)	(50,704,024.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,106,426,866.80	7,622,855,763.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,126,746,301.49)	(2,385,692,379.57)

Сайншанд сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	167,268,360.00
39217	Ном	147,224,947.52	186,626,705.63
39300	Биет бус хөрөнгө	10,791,787.28	3,032,573,482.61
39301	Програм хангамж	32,463,047.50	33,948,047.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	(21,774,385.12)	(25,160,564.89)
39303	Бусад биет бус хөрөнгө	950,000.00	3,024,736,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(846,875.10)	(950,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>33,386,983,450.24</u>	<u>39,980,176,750.61</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	108,108,073.10	94,048,959.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	108,108,073.10	94,048,959.96
41300	Өглөг	108,108,073.10	94,048,959.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	27,864,447.31	3,879,933.46
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,511,277.98	986,007.50
41360	Бусад өглөг	78,732,347.81	89,183,019.00
41361	Байгууллагад төлөх өглөг	67,581,365.00	89,142,992.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	300,000.00	40,027.00
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	10,850,982.81	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,278,875,377.14	39,886,127,790.65
51	Засгийн газрын хувь оролцоо	33,278,875,377.14	39,886,127,790.65
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,156,498,601.89	13,919,148,380.73
